

## **Музейгээс зохиох боловсролын ажлын бодлого төлөвлөлт**

Хүний шавхагдашгүй дотоод нөөц бололцоог илрүүлэн өөрийгөө илэрхийлэх боломж олгож, нийгмийн эв нэгдлийг төлөвшүүлдэг музейн ач холбогдол өсч байна. Музей өнөөдөр дэлхий ертөнц, байгаль экологийн их өөрчлөлт зэргийг тусгах, хүн ардад ойлгуулах газар болжээ. Тиймээс музейгээс олон нийтэд үзүүлэх үйлчилгээ, түүний дотор боловсролын ажлыг нийгэм, хүний эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, эрэлт хэрэгцээг бий болгох шаардлага тавигдаж байгаа юм. 2010 онд БНХАУ-ын Шанхай хотноо хуралдсан Олон улсын музейн зөвлөлийн (ОУМЗ) Ерөнхий хуралдаан музей нь залуучуудад зориулсан үйл ажиллагаандаа онцгой анхаарснаар өөр өөр соёлтой ард түмэн болон үеийнхний харилцан яриаг өрнүүлэн ойлголцлыг бий болгож, “Зохицолтой нийгмийг” (2010 оны олон улсын музейн өдрийн уриа “Музей нийгмийн зохицлийн төлөө”) бүтээх үйл хэрэгт хувь нэмрээ оруулна гэж үзсэн. (1)

Музей нь олон нийтэд зориулсан боловсролын ажлын бодлогоо тодорхойлж, төлөвлөж байж үр өгөөжтэй зохион байгуулдаг. Боловсролын хөтөлбөрийн зорилго ба үзэл баримтлал гол цөм нь болж өгөх ба зорилгоо музейн эрхэм зорилгын хүрээнд боловсруулна. Бодлого нь удирдлагын арга хэрэгсэл юм. Төлөвлөлт гэдэг нь байгууллага өмнөө тавьсан зорилгодоо хүрэх арга замыг олон хувилбараар боловсруулж, түүнээс аль оновчтойг нь сонгох ажиллагаа юм. Бодлогод юуг хийх, юуг хийхгүй вэ гэдэг зорилгоо тодруулж, шийдвэр гаргах зарчим, 5-10 жилийн стратеги гол зорилтоо тодорхойлж, 3-5 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг бичнэ. Бодлогоо боловсруулахдаа зорилтот үзэгч, санхүүгийн эх үүсвэр, үйлчилгээний төрөл, музейн дотоод гадаад үйл ажиллагаатай хэрхэн холбогдох, сургалт, реклам зар сурталчилгаа ба үнэлгээ хийх тухай оруулна.

Музейн үзмэрийн талаарх сургалт зугаатай таатай байж сургалтанд хамрагдаж буй хүмүүст хүрнэ. Тиймээс сургалтын зорилт, агуулга, арга зүй болон суралцагч суралцах үйл явц нь нямбай төлөвлөгдсөн, маш сайн зохион байгуулагдсан байх хэрэгтэй. Үзэгч музейд ирэх бүрдээ өөрийн амьдардаг нийгэм соёлын орчноо шинэ нүдээр харах боломжтой болдог. Үзмэрийн талаар зөвхөн их мэдээлэл бэлтгэснээр түүнийгээ хүргэж чадахгүй гэдгийг ойлгох нь чухал. Музейн сургалтын гол хэрэглэгдэхүүн нь үзмэр тул түүнийг “яриулах” хэрэгтэй. Бусад сургалтын байгууллагуудад мэдээллийг дамжуулагч үгийг бичгээр ба амаар хүргэдэг. Музейн ажилтнуудын оюун ухаандаа боловсруулан шинжлэх ухааны салбаруудын уулзвар дээр дэлгэн үзүүлж буй үзмэр нь үзэгчийг хүн төрөлхтөний түүхийг судлан, нэг хэсэг нь болж ойлгон мэдрэхийг урьж байдаг. Музей үзэгчдэд үзмэр үзэж, шинэ санаа олж авах ховор боломжийг олгодог бөгөөд боловсролын хөтөлбөр үзэгчийн өмнө нь мэдэж байсан зүйлс ба олж мэднэ гэж бодож байсан хүлээлт, үзмэрээс олж авах мэдлэг мэдээлэл, утга санааг хооронд нь холбож өгөх замаар тэр боломжийг улам өргөтгөж өгдөг. Ийнхүү музей хүний суурь мэдлэг ухаан, оюуны чадавхи ба ур чадварыг хөгжүүлдэг байна.(2) Музейн боловсролын хөтөлбөр сурагчдын ангиддаа үзсэн хичээлтэй холбогдож байвал тэд илүү ихийг олж авна. Харин насанд хүрэгчид өөрийн сонирхож буй болон ажил

хэрэгт нь хамааралтай сэдвийг сонирхдог.

Боловсролын хөтөлбөр наад зах нь гурван бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд: Нэгдүгээрт, сонгож авсан музейн бүрэлдэхүүн хэсэг, хоёрдугаарт, төлөвлөсөн зорилт, гуравдугаарт мэдээллийг дамжуулах арга болно. Үзэгчээ өргөтгөхийг хүсч буй музейн анхны чухал алхам нь музей үзэхүйц үзэгчид үзмэрийнх нь тухай юу мэдэж байгаа, юу мэдэхийг хүсч байгааг судлах явдал юм. Энэ мэдээллийг олж авснаар үр дүнтэй сургалт зохион байгуулах боломжтой болно. Музей сонирхолтой олон үзмэртэй байж болох хэдий ч маш тодорхой зорилт тавихгүйгээр үзүүлэлт дэлгэх үзмэр, өгүүлэх санаа, түүнийгээ дамжуулах аргаа сонгоход хүндрэлтэй байдаг.

Ямар насны, ямар бүлгийн үзэгчдэд зориулсан хөтөлбөр зохиохоо шийдсэний дараа мэдээллийнхээ агуулга, хамрах хүрээ, хэлбэр, үг хэллэгийг түүний онцлогт тохируулан хийдэг байна. Зорилт ба зорилтот зах зээлээс хамаарч, тайлбарлагчтай болон тайлбарлагчгүй аялал зохион байгуулах буюу тусгайлсан сэдэв бичих эсэхээ шийднэ. Боловсролын хөтөлбөртэй харьцуулахад үзэсгэлэн ба арга хэмжээ нь ердийн үзэгчдэд зориулагдсан байдаг байна. Гэхдээ түр үзэсгэлэнг бэлтгэх багийн нэг гишүүн нь боловсролын ажилтан байдаг бөгөөд тэрээр бусад ажилтнуудад тодорхой төрлийн үзэгчид үзэсгэлэнг хэрхэн хүлээж авах, тэдний хүлээн авах чадамж ба сонирхлын талаар мэдээлэл өгч, үзэгчдэд үзэсгэлэнд дэлгэгдсэн үзмэрийн байгаль, урлаг соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ ба олон талуудыг нээн өгдөг. Ингэснээр үзэгч авсан мэдээллээ мэдлэгтэйгээ харьцуулж, өөрийн болгох боломжтой болно.

Амжилттай, үр өгөөжтэй боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэхийн тулд үндсэн зорилгоо тодорхойлон төлөвлөж эхлэх ба төлөвлөгөөндөө хүрэх зорилго ба зорилтоо тавина. Төлөвлөлт нь дараах алхмуудаас бүрдэнэ. Үүнд:

1. Зорилго – Үндсэн зорилгодоо тулгуурлан хүрэх үр дүн
2. Зорилт – Зорилгоо тодорхой стандарт хэм хэмжээний түвшинд хэрэгжүүлэхээр үр дүнг дүгнэж болохуйц хэсгүүдэд хуваах
3. Үйл ажиллагаа – Зорилтоо хэрэгжүүлэхийн тулд хөтөлбөр зохиох, төлөвлөх, сургалт явуулах ба бэлтгэх
4. Төлөвлөгөө – Зорилгодоо хүрэхийн тулд зохион байгуулах арга тактик ба үйл ажиллагааны дэс дараалал. Хэн хэзээ юу яаж хийхийг заана.
5. Төсөв - Төлөвлөгөөгөө хэрэгжүүлж, зорилгодоо хүрэхэд хэрэгтэй хөрөнгө мөнгийг батална.
6. Ажлын хуваарилалт – Боловсролын хөтөлбөрийн үйл явцад ажлын хуваарилалт чухал хүчин зүйл юм. Хэрэгжүүлэх музейн ажилтнууд ба сайн дурын ажилтнуудыг төлөвлөх ба зорилтот үзэгчдийг хамруулах цаг хугацаа ба арга хэмжээг зохион байгуулах газрыг анхаарах хэрэгтэй.
7. Үнэлгээ – Үнэлгээ нь боловсролын хөтөлбөрийн хоёр чухал хэсгийг мэдээллээр хангана. Үүнд:

А. Хэрэгжүүлсэн хөтөлбөр тавигдсан зорилтдоо хүрсэн эсэх

Б. Хөтөлбөр төлөвлөсөн мэдээллийг аль хир өгсөн гэдгийг үнэлж, цаашид ийм төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэх удирдамж болох эсэх

Бүх насны үзэгчдэд мэдээллийг хүргэхэд хэрэглэж болохуйц наад зах нь гурван арга техник буюу мэдээллийг дамжуулах түвшин байдаг. Үүнд:

- Нэгдүгээрт шууд харилцах, энэ түвшинд боловсролын хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд тодорхой нөхцөл байдлыг бий болгож, үзэгчээс санал сэтгэгдлийг нь асуух
  - Хоёрдугаарт, үзэгчдэд тодорхой үзмэр үзүүлж, төрсөн мэдрэмжээ хуваалцаж, дүрслэхийг хүснэ. Үзэгч өөрсдийн орчин, мэдэх зүйлтэйгээ харьцуулна. Түүнээс үзүүлэлт, үзмэрээс юу харж байгаагаа өөрийн үгээр илэрхийлэхийг хүснэ. Ийнхүү үзэгч үзмэрийг ажиглаж, мэдээлэл авч сурна.
  - Гуравдугаарт үзэгчийн амьдардаг орчинтой нь үзмэрийг холбож өгөх. Үзмэрийг ажиглан ярилцсаны дүнд үзэгч тухайн үзмэр өдөр тутмын амьдралтай нь шууд холбоотой болохыг ойлгоно.
- Ийнхүү үзэгчдэд музей ховор, гайхалтай үзмэр хадгалдаг бөгөөд тэдгээр нь өөртэй нь бодит харилцан холбоотой гэдгийг ойлгуулдаг байна. (3)

1990-ээд оны дунд үед Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “музейнүүдийг сургалт, судалгааны төв болгох арга хэмжээ авах “гэж заасны дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн хорооноос 1998 онд “Музейн судалгаа, боловсрол-танин мэдэхүйн ажлыг явуулах тухай зөвлөмж” музейнүүдэд хүргэж байжээ.(4) 2001 онд батлагдсан Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуульд “Төрийн өмчлөлд байгаа соёлын өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана”(5) гэж төрийн бодлогыг тодорхойлсон. 2006 онд батлагдсан Монгол Улсын музейн стандартад боловсролын ажил гэсэн бүлэг оруулж, “Музей нь иргэд, залуучуудад зориулсан боловсролын ажлын хөтөлбөр, арга зүйг боловсруулж хэрэгжүүлнэ”, “Боловсролын ажлыг оролцогчдод хүртээмжтэй үр ашигтай байхаар зохион байгуулна” гэсэн шаардлагуудыг томъёолж, (6) олон улсын чиг хандлагыг тусгасан байна. 2009 онд батлагдсан Улс, орон нутгийн чанартай музейн дүрэмд “Сургуулийн өмнөх насны болон сургуулийн сурагчид, их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутан суралцагчид, байгууллага, иргэдэд зориулсан танин мэдэхүй, сурталчилгаа, соёл боловсролын ажлыг зохион байгуулна” гэж онцлон заажээ.(7)

МҮТМ (МҮМ) 2001-2003 онд “Монголын амьд түүх” “Монголын Үндэсний Түүхийн Музей нүүж байна” боловсролын хөтөлбөрийн бодлого, төлөвлөгөөг ерөнхий боловсролын дунд сургуулийн түүхийн багш нарын дунд судалгаа явуулсны үндсэн дээр сайн дурын ажилтан Салли Ваттерсоны хамт боловсруулан хэрэгжүүлсэн юм.

Монголын музейнүүд нийгэм, хүний хөгжилд оруулах хувь нэмрээ дээшлүүлэхийн тулд боловсролын ажлын төлөвлөлтөө сайжруулж, агуулга хэлбэрийг баяжуулан тогтмолжуулах хэрэгтэй байна. Боловсролын ажлын бодлогоо музейн эрхэм зорилго ба олон нийттэй харилцах бодлоготойгоо (коммуникацийн бодлого) уялдуулан боловсруулж, орон тооны боловсролын ажилтантай болох шаардлагатай байгаа юм. Бүр 1965 онд ОУМЗ-ийн VIII Ерөнхий хуралдаан музейнүүд боловсролын мэргэжилтэн, багш нарыг орон тоогоор ажилд авч, музейн ажлыг сургах, музейн сан хөмрөгч, судлаач нар, эрдэмтдэд музейн

сургалтын арга зүйг заах явдлыг албан ёсны бодлого болгож, Тунхаглал гаргасан.(8) Өнөөдөр ч гадаадын нилээд музей боловсролын нэг ажилтантай байх нь олонтоо тул боловсролын ажилтан нь манлайлагч, менежер, багийн гишүүн болж ажиллах чадвартай байх ёстой байдаг.

Өнөө үед ялангуяа монголын өсвөр үеийнхэнд гадны соёл нөлөөлж байгаа нь хүүхэд залуусын дунд хэрэгжүүлэх өвийн боловсролын үүрэг ач холбогдлыг улам бүр нэмэгдүүлж байна. ОХУ-ын Соёл олон нийтийн яам, Орос улсын музейн “Музейн сурган ба хүүхдийн бүтээлч үйл ажиллагааны оросын төв”, А.И.Герцены нэрэмжит Оросын багшийн их сургууль хамтран “Сайн байна уу? музей” гэдэг нэртэй дунд сургуулийн сурагчдад зориулсан музейн сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг боловсруулсан байна. Уг хөтөлбөр “Орос улсын музейд” хүүхэд залуучуудад урлагийн боловсрол, хүмүүжил олгох сургалтын үндэс болсон ба 2003 оны уран зохиол ба урлагийн салбарын төрийн шагнал хүртжээ. Сайн байна уу? Музей хөтөлбөр нь “2010 он хүртэл Оросын боловсролын системийг эрчимжүүлэх үзэл баримтлал” ОХУ-ын боловсролын талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд хийгдэж, “ОХУ-ын урлагийн боловсролын үзэл баримтлал”, “Урлагийн музей ба боловсролын байгууллагууд хамтран сургалт явуулах үзэл баримтлал” ба “Сургууль ба музей дээр залуучуудад гоо зүйн боловсрол олгох сургалтын үзэл баримтлал ба программ” гэсэн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үндсэн бүрэлдэхүүн хэсэг болж ОХУ-ын 20 гаруй бүс нутагт хэрэгжсэн байна. (9)

Ийнхүү ОХУ-ын музейнүүд сургуулийн өмнөх, дунд болон дээд боловсролын байгууллагуудтай үр бүтээлтэй хамтран ажиллаж, урлагийн болон гоо зүйн боловсролыг олгож байгаа туршлагыг манай улсад нэвтрүүлж, бүх нийтийн боловсролын талаар төрөөс баримтлах үзэл баримтлалд музейн боловсрол хүмүүжлийн асар их боломжийг тусгах нь зүйтэй юм.

### **Музейгээс зохиох боловсролын ажлын бодлого ба хөтөлбөрийн зарчим ба тэргүүлэх чиглэлийг тогтоох нь**

Музей бүр онцлог тул боловсролын ажлын бодлого, төлөвлөгөө боловсруулж буй ажилтан эрдэм шинжилгээний ажилтан ба сан хөмрөгч зэрэг ажилтнуудтайгаа зөвшилцөх бөгөөд анализ хийхдээ хэд хэдэн асуултад хариулах хэрэгтэй. Асуулт янз бүр байж болох ч дараах байдлаар байж болно. Үүнд:

#### **Музейн газар зүйн байршлын хувьд:**

1. Музей аль хир олон хүн амд үйлчилдэг вэ?
2. Музей хотод, аж үйлдвэрийн дүүрэгт, малчид тариаланчдын газар нутагт байдаг уу?
3. Газар зүйн байршлаа музей ашиглах боломж байна уу?

#### **Хүн амын нийгэм соёлын бүтцийн хувьд:**

4. Ямар үзэгчид музейг ирж үзэх вэ?
5. Ямар үзэгчдэд музейг үзүүлэх, ямар хүмүүсийг бусад үйлчилгээнд хамруулахыг хүсч байна вэ? Яагаад?
6. Нийгэм соёлын ямар уламжлалтай нутагт музей байна вэ? Түүнийг музейн зорилго бодлоготой холбож болох уу?
7. Нийгмийн амьдралд ямар тулгамдсан асуудлууд байна вэ?

**Музейн судлалын асуудлын хувьд:**

8. Музейн цуглуулга ямар гол онцлогтой вэ?
9. Цуглуулга ямар үүсэл гаралтай вэ?
10. Музей нь төр, орон нутгийн захиргаа, ивээн тэтгэгчид зэрэг бусад санхүүжүүлэгчдийн өмнө ямар үүрэг хүлээдэг вэ?

**Санхүүгийн эх үүсвэрийн хувьд:**

11. Музейгээс зохиох боловсролын ажил санхүүгийн ямар эх үүсвэртэй вэ?
12. Боловсролын хөтөлбөрт зориулагдсан музейн төсвийг хэрхэн үр бүтээлтэй зарцуулах вэ?

**Боловсролын хөтөлбөрийг боловсруулах нь: үндсэн зарчмууд**

1. Оролцогч үзэгчдийн мэдлэгийн түвшин ба амьдралын туршлагыг тогтоохоос эхэлнэ.
2. Оролцогчдод шинэ санаа, үнэмшилтэй үндэслэл гаргахад нь туслахын тулд ярилцах, хэлэлцэх боломж өгөх
3. Үзэгчийг эргэцүүлэл ба мэдрэмжээ илэрхийлэх боломжтой болгохын тулд дараах зүйлсийг хийлгэх. Үүнд:
  - Харах
  - Дүрслэн бичих
  - Хүрч үзэх
  - Хөдөлгөж үзэх
  - Зурах
  - Тоглох
4. Сурагчид ба үзэгчдээр санал бодлыг нь хэлүүлэх
5. Өөрөө сайн харах зэргээр үзмэрийг судлах цаг боломж үзэгчдэд гаргаж өгөх
6. Орон нутгийн сургуулийн хичээлийн хуваарь, улирал ба цагийг тооцож музейд ирэх цагийг зохицуулах
7. Музейн хичээл болон дадлагын байрыг танилцуулах, дасгах
8. Музейд сурагч оюутнууд сургалтаар ирэхийн өмнөх бэлтгэл ба дараах арга хэмжээг хөтөлбөрт оруулах: сургуулийн багш нарт эхэлж музей үзүүлэх буюу тэдэнд зориулан сургалт хийх, сургалтын холбогдолтой мэдээлэл материалыг урьдчилан тараах
9. Музей үзүүлсэн ба зохион байгуулсан арга хэмжээ нэг бүрийг дүгнэж, дараагийн арга хэмжээнд өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг харах (10)

Хүснэгт тал. 123-аас

2 Хүснэгт тал 190-191-ээс орно.

Ашигласан ном зохиол

1. Музей для гармоничного общества. – yandex.ru
2. Bloom and Powell(eds) (1984) Museums for a New Century, Washington, DC: American Association of Museums, p.57.
3. The handbook for museums. Gary Edson and David Dean. London and New York.1994. p.192-197.
4. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газар. 1998.12.15. Дугаар 52.
5. Монгол Улсын хууль. Соёлын өвийг хамгаалах тухай. 2001он
6. Монгол улсын стандарт. Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага. MNS5634:2006. Стандартчилал, Хэмжил зүйн үндэсний төв. УБ. 2006.тал. 14.
7. Улс, орон нутгийн чанартай музейн дүрэм. 2009.
8. Управление музеем, Практическое руководство. ИКОМ, Редактор и координатор Патрик Дж.Бойлан. Парис. 2004.с.120.
9. Многоуровневая музейно-педагогическая программа “Здравствуй, музей!” Государственный Русский музей, С-П. 2005.
- 10.Управление музеем, Практическое руководство. ИКОМ, Редактор и координатор Патрик Дж.Бойлан. Парис. 2004.с.122, 124.Running a museum.A Practical Handbook.ICOM- International Council of Museum. Editorial Coordinator-Patrick J. Boylan. Paris.2004.
- 11.Eilean Hooper-Greenhill. Museum and Gallery Education. Leicester University Press. Leicester, London and New York. 1991.p.117.  
Управление музеем, Практическое руководство. ИКОМ, Редактор и координатор Патрик Дж.Бойлан. Парис. 2004.с.123.
- 12.Eilean Hooper-Greenhill. Museum and Gallery Education. Leicester University Press. Leicester, London and New York. 1991. p.190-191.

Бэлтгэсэн: **Д.Бумаа Ph.D**

(МҮМ-н Музей судлалын мэргэжил арга зүйн төвийн дарга)